

ГАН ХИЙЦ ХК

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.03.30



НЭГ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Тайлант онд урьд оноос борлуулалтын түвшин, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо хэмжээг буулгахгүй байх зорилт тавьж ажилласан болно.

2016онд Ган хийц ХК-ийн үндсэн үйлдвэрлэл дараах чиглэлүүдээр явагдсан. Үүнд:

- Төмөр хийц эдлэл үйлдвэрлэл
- Барилга угсралт

Ган хийц ХК-ийн 2016 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг 94134400 төгрөг, ЗАА зардлын төсвийг 955428949 төгрөгөөр, борлуулалтын хэмжээг 4,75 тэрбум төгрөгөөр баталж өгсөн ба гүйцэтгэлээр дараах байдалтай байна.


№	Нэр	Төсөв	Төсвийн гүйцэтгэл
1	ТУЗ-ийн зардал	94 134 400	84 412 613,97
2	ЗАА зардал	955 428 949	654 789 679,66
3	Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралтын борлуулалт	4 750 000 000	1 714 451 982,50

Хавсралтаар төсвийн гүйцэтгэлийн задаргааг харуулав.

2015-2016 оны борлуулалтын орлого

№		2012	2013	2014	2015	2016
1	Төмөр хийцийн жин	300	300	513	160	215,13
2	Борлуулалтын орлого	600	325	1400	738,7	1714,4

Төмөр хийцийн үйлдвэрлэлтийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн харьцуулалт



Материал татан авалтыг боловсронгуй болгож, материал байнгын авдаг харилцагчтай болох. Өмнөх жилүүдэд томоохон ажлын материалыг Эрээн хотоос авдаг байсныг үргэлжлүүлэх болно.

2016 онд дараах томоохон ажилуудыг хийж гүйцэтгэсэн байна.

он	Захиалагчийн нэр	Хийсэн ажил	Үнэ
2016	Суруга Монгол ХХК	Гүүрэн дам нуруу	62502000
2016	Ган-эрдэнэ констракшн ХХК	Сэндвичэн барилгын төмөр хийц, дээвэр	9050000
2016	Зэвсэгт хүчний 017-р цэргийн анги	Сэндвичэн барилгын төмөр хийц	190 000 000
2016	Пирамид Прокет ХХК	Ферм	34000000
2016	Мон ор ХХК	Төмөр хийц	57635000
2016	Роял групп ХХК	Металл дээвэр	13140000
2016	Дорнод аймгийн ЗДТГын барилга	Дам нуруу	1066914029
2016	UBS телевиз	Төмөр хийц	84753515
	дүн		1517994544


2016 онд Улсын төсөвт 290 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

№	Татвар	2016
1	НДШ	82093744.94
2	НӨАТ	171445198
3	ХАОАТ	27857068.07
4	Үл хөдлөх	5792980
5	Тээврийн хэрэгсэл	1030800
6	ААНОАТатвар	
7	Газрын татвар	2370192
	Дүн	290 589 983,01

УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн удирдлага бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

Ган хийц ХКийг 2016 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга М.Даваасүрэн удирдан явуулж байсан бөгөөд 2016 оны 11 дүгээр сарын 14-ны өдрөөс эхлэн Цагаан овогтой Батбаярыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр хоёр сарын хугацаатай томилсон бөгөөд 2017 оны 02 дугаар сарын 17ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар Ц.Батбаярыг гүйцэтгэх захирлаар томилсон.



ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр компанийн тухай хууль болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ.

Аудитын хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан хувьцаат компани нь санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар аудит хийлгэх шаардлагатай болсон учир компанийн дүрмийн 11.12-т нэмэлт заалт оруулж Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, “Ай жэй эй эйч аудит” ХХК-тай 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдөр Аудитын үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна.

Орон тоо бүтцийн талаар:

ТУЗ-ын хурлаар баталсан ЗАА-н орон тооны бүтцийн дагуу зохих хүмүүсийг авч ажиллуулсан ба зарим нэг орон тоон дээр хавсран ажиллаж байлаа. Цаашид орон тооны дагуу хүмүүсийг авч ажиллуулах, шаардлага хангасан мэргэжилтнүүдийг авч ажиллуулахад анхаарах нь зүйтэй гэж бодож байна.


2016оны ТУЗ болон Захиргаа , үйлчилгээний хэсгийн орон тоо цалингийн төсвийн гүйцэтгэл дараах байдалтай байна энэ хэмнэлт нь хэд хэдэн орон тоо сул байсан бөгөөд эдийн засгийн хямралтай үед өөрсдийн ажиллах хүчинээ нэмэхгүйгээр байгаа хүмүүсээрээ ажилласан болно. Мөн манай компани дээр үйл ажиллагаа явуулж байгаа Эко цаг ХХК, Ган хийц Сэндвич хавтангийн үйлдвэр ХХК-уудад харуул хамгаалалтын асуудлыг хэлэлцэн, 6 харуулыг 3 компани дээрээ хувааж авч цалинжуулахаар болсон.

№		Төсөв	Гүйцэтгэл
1	Зархигaa, үйлчилгээний хэсгийн орон тоо, цалингийн сан	360 700 800	252 420 790,35
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардал	39 120 000	36 705 430

Хавсралтаар төсвийн гүйцэтгэлийн задаргааг харуулав

2016 онд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Барилга хариуцсан захирал, Нарийн бичгийн дарга нар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. 2017 ондоо ажилтан, албан хаагчдаа мэргэжил дээшлүүлэх шат шатны сургалтад хамруулах төлөвлөгөөтэй байна.

Компанийн мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс веб сайт шинэчлэгдэж, Хувьцаа эзэмшигчдэд зориулан булан гаргасан бөгөөд компанийн холбогдолтой бүхий л мэдээллийг авах боломжтой юм.



Шагнал тэтгэмж, тусламж

2016 онд байгууллагынхаа 30 жилийн ойн хүрээнд ажилчид болон оршин байгаа нутаг дэвсгэрийнхээ байгууллага, ард иргэдэд харамгүй дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирсэн. Мөн Төрийн дээд болон салбарын шагналаар шагнагдаж байна.

1. Компанийн өндөр настан ахмадууд, гарын бэлэг гардуулж, компанийн үйл ажиллагаатай танилцуулсан. Үүнд 3 602 000 төгрөгийн зарцуулсан байна.
2. Компанийн Ерөнхий инженер Б.Ганбат, Барилга хариуцсан захирал Ц.Пүрэвжаргал нар нь Тэргүүний барилгачин цол тэмдгээр шагнагдсан, Мөн Санхүүгийн албаны нягтлан бодогч Л.Болор-эндэнэ Сангийн яамны жуух бичгээр, Хүний нөөцийн менежер О.Ууганцэцэг нь Хөдөлмөрийн яамны Тэргүүний ажилтнаар тус тус шагнагдаж, шагналд 636000 төгрөгийг зарцуулсан байна.
3. Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр болон шинэ жилийн баярыг тохиолдуулан компанийн ажилчдын хүүхдүүдэд бэлэг дурсгалын зүйл гардуулсан. Үүнд 1390000 төгрөгийг зарцуулсан байна.
4. Нийгмийн даатгалын салбар үүсч хөгжсөний 75 жилийн ойг тохиолдуулан 200000 төгрөгийн шагнал олгосон.
5. Ардын хувьсгалын 95 жилийн ойн арга хэмжээг угтан Б.Галсанжамц, Д.Өлзийбаяр нарын МУ-ын Хөдөлмөрийн хүндэт медаль, О.Очирыг Осолгүй манлай жолооч, Б.Мөнхбат, П.Ариунаа, Ч.Мядагмаа, Ч.Төрмөнх нарыг Тэргүүний барилгачин цол тэмдгээр, Н.Түмэнбаяр, Ж.Уранбилэг, Н.Батхишиг, Д.Цэдэнбал нарыг Хүндэт жуух бичгээр шагнаж, урамшуулсан.

ХОЁР. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар 2016 оны санхүүгийн тайланг хэлэлцэж, Төлөөлөн удирдах зөвлөл нь Хангалттай гэсэн дүгнэлт өгсөн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 13:10 минутанд өндөрлөв.

Шийдвэрлэсэн нь:

1. Ган хийц ХКомпанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн Хангалттай гэж дүгнэв.
2. Компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 03-р сарын 29-н өдрийн 11:40 цагаас компанийн хурлын байранд хуралдуулахаар шийдвэрлэв.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах асуулыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 - Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
 - ТУЗ-ийн 2017 оны зардлын төсөв, Компанийн үйл ажиллагааны 2017 оны зардлын төсөв батлах
 - ТУЗ-ийн ажиллах журам батлах
4. Цагаан овогтой Батбаярыг Ган хийц ХК-ийн Гүйцэтгэх захиралаар 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн томилов.

Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа гаргасан тухай мэдээлэл

МУ-ын засгийн газраас баталсан Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд авсан 1,44 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй бөгөөд сард 28 сая төгрөгийг зээлийн хүү төлж байна.

2016 онд өр авлагыг барагдуулах талаар

Манай компанийн 2016 оны Сонгино-хайрхан дүүргийн ИХАШ шүүхэд нэхэмжлэгчээр оролцсон бөгөөд Ди ЭлЖи ХХК-иас 121725954 төгрөгийг манай компанид олговроор шийдвэрлэсэн.

Мөн Сонгино хайрхан дүүргийн 7 хорооны барилгад хөрөнгө оруулалт хийсэн асуудлаараа 2014 оноос хойш шүүхээр явж байгаа бөгөөд 2017 оны 01 дүгээр сард Нийслэлийн өмчийн харилцааны газраас 11 сая төгрөгийг манай компанид олгохоор шийдвэрлэсэн.

2016 оны санхүүгийн тайланг хавсралт-1-ээр үзүүлэв.

ГУРАВ.НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

4.1. Компанийн тухай жилд тараасан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг тараагаагүй тохиолдолд түүний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл

2015 онд цэвэр ашгаас нэгж хувьцаанд олгох ногдол ашгийн хэмжээг 100 төгрөгөөр тогтоож, 242464 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг 122 хувьцаа эзэмшигчдэд 24246400 төгрөгийн ногдол ашиг хувиарлахаар баталсан. 2016 оны 08 дугаар сард Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар зуучлуулан ногдол ашиг тараалгах гэрээ байгуулан 100 хувьцаа эзэмшигчийн 13682 ширхэг хувьцаанд ногдох 1231380 төгрөгийг шилжүүлэн, дансанд нь байршуулсан бөгөөд 22 хувьцаа эзэмшигчийн 228782 ширхэг хувьцаанд ногдох ногдол ашгийг компани дээрээс тараахаар болсон.

2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэгж хувьцаанд 100 төгрөг тараахаар шийдвэрлэсэн.

Уг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулна.

5. Ц.Батбаяртай Гүйцэтгэх захирлын гэрээ байгуулах ажиллахыг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэнд даалгав.
6. 2016 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр тогтоож, холбогдох Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгохыг ТУЗ-ийн дарга /М.Даваасүрэн/-д даалгасугай.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  О.Ууганбилэг

ТУЗ-ийн дарга 

ТУЗ-ийн гишүүд

М.ДАВААСҮРЭН

З.БАТХААН

Б.ЭРДЭНЗБЯЛАГ 

Ц.ПУРЭВЖАРГАЛ 


Б.ГАНБАТ 

Р.ЭРДЭНЦОГТ 

П.ТӨВСАНАА 

Д.ЭНХБААТАР

Э.ДОЛГОРСҮРЭН 



2017 ОНД ТӨЛӨВЛӨСӨН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

Компанийн хүрэхээр төлөвлөж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратеги, үр дүнгийн үзүүлэлтийг SWOT шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, бусад судалгаа болон ажилчдаас ирсэн санаа бодлыг үндэслэн тодорхойлов.

<p>Компанийн зорилго, зорилт</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Зардлыг багасгах, орлогыг нэмэгдүүлж, компанийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх. ▪ Үйлдвэрлэлийн шат дамжлагуудыг автоматжуулж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх. ▪ Эдийн засгийн хямралтай үед бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо хэмжээг бууруулахгүй байх. ▪ 2017 оныг ХАБЭА-н жил болгоно. ▪ Одоо явуулж буй 2 үндсэн үйл ажиллагаан дээр нэмж, ирэх 5 жилд уул уурхайн болон дэд бүтцэд хэрэгтэй онцлог төмөр хийц болон тоног төхөөрөмжийн нарийн сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэгч компани болох.
<p>Төлөвлөсөнүйлажил лагаа</p>	<ul style="list-style-type: none"> ▪ 2017 оны төлөвлөгөөг боловсруулахад 2015, 2016 онуудын орлого, зардлын бодит гүйцэтгэл, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн судалгаа, хэлтэс нэгжүүд, үйлдвэрлэл, цехүүдийн тайлан тооцоо, төлөвлөгөөний санал зэргийг үндэслэл болгохоос гадна 2016 оны төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалтыг судлан түүнд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлүүдийг тооцон боловсрууллаа. ▪ Компани стратеги /урт хугацааны төлөвлөлт ирэх 5 жилд/ - Ирэх 5 жилд уул уурхайн болон дэд бүтцэд хэрэгтэй онцлог Төмөр хийц болон тоног төхөөрөмжийн нарийн сэлбэг хэрэгсэл Үйлдвэрлэгч компани болох. Ган хийц компанийн брэнд Бүтээгдэхүүнтэй болох. -Даацын Н хэлбэрийн ган бүтээц хийдэг шугамтай болох <p><u>Хийгдэх ажлууд</u></p> <p>Эхний жилд зорилтот хэрэглэгчээ тодорхойлж, ямар бүтээгдэхүүндээ зориулж ямар тоног төхөөрөмжөөр хийх зэрэг зах зээлийн судалгаа хийх. /одоогоор хийгдэж байгаа/ 2 дахь жилээс хэрэв санхүүгийн асуудал шийдэгдвэл /дотоод компани нөөц боломжоор шийдэх эсвэл гадаад хөрөнгө оруулалтаар шийдэх /тоног төхөөрөмж худалдан авах, боловсон хүчин бэлдэх. 3 дахь жилээс туршилтын сэлбэг хэрэгсэл тоног төхөөрөмж Үйлдвэрлэх ажлыг эхлүүлэх. 4, 5 дахь жилээс үйл ажиллагааг жигдрүүлж, үйлдвэрлэл эхлэх.</p> <p><u>Шаардагдах машин, тоног төхөөрөмж</u> CNC машинууд- дижитал удирдлагатай олон үйлдэлтэй токарин, өрмийн болон фрейзерийн машин босоо болон хөндлөн тэнхлэгтэй, лазерын зүсэгч, Н хэлбэрийн ган бүтээц үйлдвэрлэх шугамын тоног төхөөрөмж.</p> <p><u>Үр өгөөж, шалтгаан</u> Одоогоор тооцоолж байгаагаар – өөрсдийн компанийнхаа хэрэгцээт тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгслийг өөрсдөө хийх мөн бусад захиалгаар сэлбэг хэрэгсэл бусад компанид нийлүүлэх, том салбарууд болох уул уурхай, дэд бүтцийн салбарын нарийн тоног төхөөрөмж сэлбэгийг дотооддоо хийх, эдгээр салбаруудад маш том зах зээл байна гэж одоогоор хийгдэж байгаа судалгаагаар</p>

харагдаж байгаа.

- Бүрэн БА, ББ-ийн зураг төсөл хийдэг болох. Үүний тулд мэргэжлийн архитектуртай болох.

- Компанийн хэтийн төлөв стратеги, ирээдүйн бодлогыг харж судалгаа хөгжүүлэлт хийдэг байх, баг бүрдүүлэх.

- **Маркетингийн төлөвлөлт** /богино хугацааны төлөвлөлт ирэх 1 жилд/

Энэ богино хугацааны төлөвлөлтийг тодорхой, ойлгомжтой

Болгохүүднээс салбар нэгж бүрээр нь хийлээ.

а)Компанийн ерөнхий үйл ажиллагааны хувьд

-Эдийн засгийн энэ хямралтай үед, 2016 онд хийсэн төмөр хийцийн үйлдвэрлэл, угсралтын хэмжээг 2017 онд бууруулахгүйгээр байлгах, бүх нөөц бололцоогоо дайчлан хямралыг даван гарах. Нөгөө талаар хямралыг боломж гэж харж, хариу стратеги төлөвлөгөөтэй ажиллах.

- Компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчилж, энгийн, чадварлаг болгох.

б) Удирдлагын хүрээнд

Удирдлага ажилчдын үүрэг, хариуцлага, хяналтын системийг

Бий болгосон.

Удирдлагын багийг 7 хүний бүрэлдэхүүнтэй зохион

байгуулсан. Гишүүд-

Ц.Батбаяр

Б.Ганбат

Ц.Пүрэвжаргал

Н.Батхишиг

Т.Буяннэмэх

Б.Баярмаа

О.Ууганцэцэг

Энэхүү удирдлага ажилчдын үүрэг, хяналт, хариуцлагын систем нь компанийг нэгдсэн удирдлагаар хангах, өдөр тутмын өгсөн үүрэг даалгавар, ажлын биелэлтийг, системтэйгээр хянах, хариуцлага тооцох хүлээлгэх, Компанийн үйл ажиллагааг бүх нэгж хэсэгт оновчтой жигд Хэвийн явуулахад оршино. Энэ удирдлагын багийг гүйцэтгэх, Захирал ерөнхийд нь удирдах бөгөөд шийдвэрийг бүх гишүүд зөвлөлдсөний эцэст гаргана. Мөн компанийн дотоод дүрэм журмуудыг компани дээр хэрэгжүүлэхэд энэ системийн гол зорилго юм.

Хийгдэх ажлууд

Ухаалаг хүснэгтийг бүх салбар нэгжүүдэд хэрэглэж эхлэх, Цаашид хөгжүүлэх. Ухаалаг хүснэгт нь үүлэн системд суурилсан бөгөөд, 1 жилийн эрх авахад \$150 орчим доллар болох тул энэ мөнгийг 2017 оны үйл ажиллагааны төсөвт суулгах.

в)ХАБЭА хүрээнд

Ган хийц ХК-ны хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг Бүх салбар нэгж, бүх ажилчдад дагаж мөрдүүлэх ажлыг хийж, Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Хийгдэх ажлууд

-Компанид нийт 17 ширхэг том жижиг тоног төхөөрөмж байгаагаас 8 машин тоног төхөөрөмж эвдрэлтэй, хөдөлмөр хамгаалалын шаардлага хангахгүй байгаа учраас засах хөрөнгө мөнгийг 2017 оны төсөвт оруулж батлуулах, цаашид эдгээр тоног төхөөрөмжүүдийг техникийн паспорттай болгож, засвар үйлчилгээг тогтмол хийж, тэмдэглэдэг болгох.

-Галын хор, бусадХАБЭАсамбар тэмдэгтүүдийг зохих Газруудад байрлуулах, тогтмол сургалт явуулах- графикийн Дагуу ажлуудыг хийх.

-Одоо байгаа үйлдвэр цех, оффисийн барилгын бүх Цахилгааны монтаж, самбаруудыг

засаж, галын аюулгүйн Шаардлагад нийцүүлэн засах.

-Графикийн дагуу байнга шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгах, дүн шинжилгээ үнэлгээ өгдөг болгох. Удирдлага болон ажилчдаас бүрдсэн байнгын комисс графикийн дагуу ажиллуулах.

г) Үйлдвэрлэл, барилга угсралтын хүрээнд

-Төмөр хийцийн үйлдвэрлэлийг явал үр ашигтай ажиллуулж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж дээр үргэлжлүүлж судалгаа хийж, зөв менежмент олох тал дээр ажиллах. /cost management/

-Нэгж бүтээгдэхүүний өртгийн тооцоог хийх

-Материалын хорогдлыг нормоос хэтрүүлэхгүй байлгах

-Борлуулалт дээр нарийн судалгаа хийх, нэгж алба байгуулах тал дээр ажиллах

-Компанийн нөөц бололцоог харгалзан ажилчдын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх тал дээр илүү анхаарч ажиллах.

-Дээр дурдсан тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх тал дээр илүү анхаарч ажиллах.

-Зураг төслөөс эхлээд бүтээгдэхүүн болох хүртэл хөндлөнгийн эсвэл чанарын инженерийн шалгалтаар ордог болгох. Үүний тулд чанарын инженертэй болох. Сэндвичний үйлдвэртэй дундаасаа цалинжуулах, манай 2 компанийн бараа бүтээгдэхүүний чанар нэг нэгнээсээ хамааралтай учраас ийм байдлаар зохион байгуулбал цогц, оновчтой гэж үзэж байна. 2017 оны төсөвт чанарын инженерийн орон тоог суулгах. Ингэснээр манай 2 компани нь,

стандартын материал худалдан авахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх стандарт, технологид хяналт тавих боломжтой болж өрсөлдөх чадвар дээшлэх юм.

д) Захиргаа аж ахуйн хүрээнд

-Дотоод хяналтын баг /хороо, комиссыг/ удирдлага, ажилчид дундаас байгуулж ажиллуулж, компани бүх салбар нэгжид хяналт тавьж, дотоод хяналтыг сайжруулах, чиг үүргээр хангаж, байнгын ажиллуулах.

-Бараа материал худалдан авахдаа, тогтмол хамтран ажиллах Нийлүүлэгч олох. /цаашилбал хамтрагч олж, өөрсдийн төмрийн зах нээх ажил дээр илүү анхаарч ажиллах.

-Хүний нөөцийн бодлого дээр анхаарч ажиллах, зөв хүмүүсийг ажилд авах, ажилд авах гарах процессыг дэг журамтай болгох.

-Маркетингийн менежертэй болох. Одоогоор маркетингийн төсөл явагдаж байгаа, маркетингийн баг ажиллаж байгаа, төсөл хэрэгжиж дуусаад дүгнэлт хийсний үндсэн дээр, менежер, маркетингийн алба байгуулах тал дээр шийдвэр гаргана.

-Бараа материалын нярав, мөнгөний няравын ажлыг салгаж ажиллуулах. Нягтлан бодох бүртгэлийн стандарт журамд нийцэхгүй байна. Байнгын сууж байдаг мөнгөний нярав авах, мөн давхар харуул хамгаалалтыг хариуцуулж–лац ломбо бараа материалыг хариуцаж хүлээлцүүлж ажилладаг болгох. Бэлэн мөнгөний нярав ажилд авах, 2017 оны төсөвт орон тоог суулгах.

-2 давхарт ажилчидын 00 өрөөг засаж дуусгах. 2017 оны төсөвт Зардлыг суулгах.

е) Үйлдвэрлэл цехийн хүрээнд

Энэ ондоо багтааж үйлдвэрлэлд хэрэглэгдэх нэн чухал шаардлагатай байгаа дараах багаж, тоног төхөөрөмжүүдтэй болох.

-Цахилгаан хий хосолсон зүсэгч машин

-Элсэн цэвэрлэгээний машин

-Бүх цахилгаан нуман гагнуурыг хагас болон бүрэн автоматаар

солих

-Суурь автомат хөрөөний машин /даацын элемент Н, L, С хэлбэрийн төмөр тайрах зориулалттай/ эдгээр 4 тоног төхөөрөмжийг зайлшгүй авах эдийн засгийн болон чанарын шаардлагын хэрэгцээтэй байна. Инженер, ажилчдын санаа бодол, судалгаан дээр

	<p>тулгуурласан болно. Хэсэгчлэн 2017 оны төсөвт суулгах. Эсвэл бусад эх үүсвэрээр шийдэх.</p> <p>-Эдийн засгийн үр ашиг болон чанар</p> <p>Одоо манай компанийн хэрэглэж байгаа гагнуурын аппаратууд чанарын шаардлага хангахгүй зарим даацын элемент гагнахад, их цахилгаан хэрэглэдэг зэрэг нь эдийн засгийн үр ашиг муутай байна. Элсэн цэвэрлэгээний машин байхгүйгээс төмөр хийцүүд сайн цэвэрлэгдэхгүйгээр будганд орж чанаргүй бүтээгдэхүүн гарч манай компаний өрсөлдөх чадварыг бууруулж байна. Суурь автомат хөрөөний машин, цахилгаан хий хосолсон Зүсэгч машинтай болсноор хөдөлмөрийг хөнгөвчилж, ажлын бүтээмж сайжирч чанартай бүтээгдэхүүн гарах боломжтой. Энэ хөрөнгө оруулалтыг хийснээр урт хугацаанд зардлаа хэмнэлтээрээ нөхөж, өрсөлдөх чадвараа сайжруулж, үйлдвэрлэлийг автоматжуулах манай гол зорилгуудын нэг алхам алхмаар хэрэгжих юм.</p> <p>-Үйлдвэрийн дээврийг ус гоожихгүй болгож, засвар хийх. 2017 оны төсөвт суулгах.</p> <p>-Материалын талбай, складыг цэвэрлэж эмх цэгцтэй болгох.</p> <p>-Бүх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эзэнтэй болгох.</p> <p>к) Бараа материалын худалдан авалт, хэрэглээ, чанар, стандарт</p> <p>-Дээр дурдсан бараа материал байнгын авдаг харилцагчтай болох. Чанар стандарт хангасан бараа материалыг зах зээлийн үнээр авах.</p> <p>-Илүүдэл бараа материал нөөцийг коджуулж системд оруулах,</p> <p>Зөв зохистой, эдийн засгийн үр өгөөжтэй зарцуулж, материалын хорогдолгүй ашиглах,</p> <p><u>Хийгдэх ажил</u></p> <p>Ухаалаг хүснэгтийг нэвтрүүлэх, хэрэглэх, хөгжүүлэх. Ухаалаг хүснэгтийг хэрэглэснээр бараа материал захиалах процесс хурдан шуурхай болно, шилэн болно, складад ямар бараа материалын нөөц бидэнд байгааг бүх нэгж салбар, Удирдлагын түвшинд мэдэх боломжтой юм.</p> <p>л) Ган хийц ХК-ны салбар компаниудын уялдаа холбоо</p> <p>- Салбар компаниудын гүйцэтгэх захирлуудтай хамтарч, компаниудын хоорондох уялдаа холбоо, харилцааг зохицуулсан баримт бичиг, дүрэм журмыг боловсруулах.</p>
<p>Борлуулалт, маркетингийн төлөвлөгөө</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Одоо ажиллаж байгаа маркетингийн баг 2017 оны маркетингийн төлөвлөгөөг гаргана. Тэгээд цааш ямар бүтэц зохион байгуулалтаар яаж ажиллахаа тодорхойлно. /Маркетингийн менежертэй болох, төсөвт суулгах/ ▪ Үйлчилгээг чанартай болгох, үйлчлүүлэгчдэд урамшууллын системийг олон янзаар үзүүлж байх. ▪ Дотоод боловсон хүчний нөөцөд тулгуурлан ажлыг зөв хуваарилан борлуулалт, маркетингийн ажлыг зохион байгуулж хэрэглэгч, өрсөлдөгч, орчны шинжилгээг нарийвчлан хийж, гадаад дотоод бодлого, бүтээгдэхүүний чанар, үнэ өртөг, зардлыг сайтар судлан үнэлэлт дүгнэлтийг зөв өгч дүгнэлтийн дагуу арга хэмжээ авдаг болгох.
<p>Менежментийн төлөвлөгөө</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Төлөвлөлтийг макро болон микро бүх шатанд хэрэглэж бизнесийн үйл ажиллагааг зохицуулах гол хэрэгсэл болгон ашиглаж бизнесийн ажиллагааны үр дүн нь тодорхой зорилго, тооцоо судалгаатай сайтар боловсруулсан төлөвлөгөөт зорилтуудыг биелүүлнэ. ▪ Ажилчид-удирдлагын хамтын ажиллагааны хэлбэр болох хамтын гэрээ, ажилчдыг хөгжүүлэх, мэргэжил, мэргэшил дээшлүүлэх, шинээр олгох, өндөр ур чадвартай ажлын баг байгуулах зэрэг ажлын шинэ зохион байгуулалт нэвтрүүлэх. ▪ Боловсон хүчний бодлогыг зөв барьж, инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн болон менежментийн ур чадварыг байнга дээшлүүлж байх. ▪ Үйлдвэрлэлийн онцлогт тохирсон хөдөлмөр хамгааллын шаардлага хангасан ажлын байр, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах, хөдөлмөр амралтын горимыг оновчтой тогтоож, эрүүл ахуйн нөхцөлийг дээшлүүлэх,

	хүнд хортой нөхцөлд ажиллагсдыг сүү, хордлогоос сэргийлэх бусад бүтээгдэхүүнээр байнга хангах зэрэг арга хэмжээг авна.
Санхүүгийн төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> ▪ 2017 оны бидний зорилт нь эдийн засгийн судалгаа шинжилгээг түлхүү хийж, санхүүгийн программын авлага, өглөг, бараа материал, хангамжийн материалын бодит үлдэгдлийг тайлагнах, нягтлан бодох бүртгэлийн дансны харилцаанд алдаатай ажил гүйлгээг хийхгүй байх талаар анхаарч ажиллах./нэгж бүтээгдэхүүний өртгийн тооцоо хийлгүүлэх/ ▪ Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийг хэрэгжүүлж, бүртгэл хяналтын олон улсын стандартыг улам боловсронгуй болгож хэрэгжүүлэх. ▪ Бүтээгдэхүүний үнэ өртөг, ашиг зэргийг зөв тодорхойлж, судалгаа, хөгжүүлэлт хийдэг болгох. ▪ Өр, авлагыг багасгах. ▪ Үргүй зардлыг багасгаж, орлогын нэг төгрөгт ногдох зардлыг төлөвлөсөн хэмжээнээс өндөржүүлэхгүй байх. ▪ Бараа гүйлгээг хөнгөн шуурхай болгохоос гадна хяналт, шалгалтын ажлыг хэсэгчлэн тусгай төлөвлөгөөтэй хийж гүйцэтгэж байх. <p><u>Хийгдэх ажлууд</u></p> <p>-Санхүү, нягтлан бодох бүртгэлийг шилэн, хурдан хугацаанд тайлан тооцоо гаргах, дүн шинжилгээ хийх, түүнийг танилцуулахад хялбар, хяналт тавих, автоматжуулах үүднээс ухаалаг хүснэгтийг нябо санхүүгийн хэлтэст нэвтрүүлж, хэрэглэх, хөгжүүлэх ажлуудыг хийнэ.</p>
Хүний нөөцийн менежмент	<ul style="list-style-type: none"> ▪ Мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх мэргэжлийн сургууль дамжаа төгсөгчдийг авч ажиллуулахын хамт дадлага туршлагатай хүмүүсээр дадлагажуулах, мэргэжлийн зэрэг ахиулах сургалтад хамруулах. ▪ Хэлтэс албадын удирдах ажилтнуудыг дотоод гадаадын менежмент, маркетингийн чиглэлийн богино хугацааны сургалтад оролцуулан мэдлэг ур чадварыг дээшлүүлэх.
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	<ul style="list-style-type: none"> ▪ Хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгө оруулалтаар хийгдсэн үйлдвэрлэл техникийн эдэлгээг уртасгах, ажиллах зохион байгуулалтын ажлыг сайжруулах. ▪ Компанид ашигтай хөрөнгө оруулалтыг байнга судалж байх.
Эрсдлийн менежмент	<ul style="list-style-type: none"> ▪ Эрсдэлийн шинжилгээг цаашид олон аргаар хийх, байнга мониторинг хийх /эрсдлийн менежемент явуулах/ ▪ Компанийн эрсдэлийн санг байгуулах, журам гаргах. ▪ Эрсдэлтэй шийдвэр гарсан тохиолдолд маш яаралтай арга хэмжээ авч зогсоож байх.